Олон
Улсын
Хөдөлмөрийн
Байгууллага

75
ЖИЛ

АЗИЙН ОРНУУДАД ҮЙЛДВЭРЛЭЛИЙН АЮУЛТАЙ ХҮЧИН ЗҮЙЛЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ТАЛААР ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ АРГА ХЭМЖЭЭНҮҮД

/ ГАРЫН АВЛАГА /



ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ХЯНАЛТЫН АЛБА
ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА, ЭРҮҮЛ АХУЙН
ҮНДЭСНИЙ МЭДЭЭЛЛИЙН ТӨВ

1997 ОН

94B09/515
mong cp.4

40220

ӨМНӨХ ҮГ

Ази, Номхон далайн бүсийн орнуудын эдийн засгийн хурдацтай хөгжил нь амьдралын хэв шинжийг сайжруулах, орлогыг нэмэгдүүлэх ач холбогдолтой байгаа хэдий боловч, үйлдвэржүүлэлтийн хурдац нь осолд өртөгсөд болон ослын улмаас нас барах хүмүүсийн тоог нэмэгдүүлэх үр дагавартай байна. Үйлдвэрлэлийн аюултай нөхцөл бүхий хөдөлмөрийн нөлөөллөөс ажилчдыг хамгаалах ажлыг сайжруулах нь амьдралын аль ч түвшинд шаардагдах боллоо.

ОУХБ-аас өнгөрсөн 75 жилийн турш ажилчдын эрх ашгийг хамгаалахын төлөө тэмцэж ирсэн билээ. ОУХБ-аас жил бүр чуулдаг Олон улсын Хөдөлмөрийн хурлаар хөдөлмөрийн төрөл бүрийн аюултай хүчин зүйлийн нөлөөллөөс ажилчдыг хамгаалахын тулд Олон улсын стандартыг батлан гаргаж байна.

Энэ товхимолд тус бүс нутаг дахь аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн асуудлын ерөнхий байдал, онцгой анхаарал хандуулах зарим асуудлыг товч тусгасан болно. Мөн үндэсний болон үйлдвэрийн түвшинд ажилчдын аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн асуудлыг сайжруулахад хийх хэрэгтэй бодит алхамуудыг авч үзлээ. Энэ товхимолыг 1994 онд болсон ОУХБ-ын 75 жилийн ойг тохиолдуулан ОУХБ-ын Бангкок дахь товчоо хэвлэсэн юм

Энэ товхимлыг ОУХБ-ын Зүүн Азийн Зөвлөх Товчооны хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, техникийн эрүүл ахуйн мэргэжилтэн ноён Сэйжи Мачидагийн удирдлага дор хэвлэлд бэлтгэсэн болно. Энэ номын баримт материалыг эмхлэн цэгцэлсэн, ОУХБ-ын зөвлөх мэргэжилтэн доктор Казутака Когид талархсанаа илэрхийлье.

Энэ товхимол нь бүсийн орнуудын Засгийн газар, Эзэд, Ажилчдын (ҮЭ) байгууллагуудад тэдгээрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн асуудлаар явуулах үйл ажиллагааг сайжруулахад үр дүн өгнө гэдэгт найдаж байна.

RECEIVED
1 8 NOV 1997
International
Labour Office
ILO BIT

ASSEFA BEGUELE
ОУХБ-ын Зүүн Азийн бүсийн орнуудын зөвлөх хэсгийн захирал (Бангкок дахь ОУХБ-ын бүсийн товчоо)

Бангкок
1994 оны 12-р сар.

ГАРЧИГ

1.Нөхцөл байдал ба хамарч буй хүрээ	1
2.Хөдөлмөрийн аюултай нөхцөл бүхий ажлын байрны хүрээн дэх бэрхшээлүүд	3
3.Үйл ажиллагааны бүрэлдэхүүн ба бодит алхмууд	4
- Уулзалт чухал хэрэгтэй	4
- Үйл ажиллагааны үндэсний хөтөлбөрийн бүрэлдэхүүн	4
- Үйл ажиллагааны хувьд голлон анхаарах үйлдвэрүүд ба хөдөлмөрийг сонгох	6
- Бодит алхмууд	6
- Нөөц бололцоо ба туршлага	8
4.Бодлогын бүтэц	9
- Гурван талт хамтын ажиллагаа	9
- Үйл ажиллагааг хэрэгжүүлэх сонголт	10
5.Хууль тогтоомж ба дүрэм журам	11
- Нийгмийн оролцогч талуудын үүрэг	11
- Эрсдлийн хяналт	12
- Урьдчилан сэргийлэх тусгай арга хэмжээ	13
- ХААЭА-н удирдлага, зохион байгуулалт	13
- Стандарт ба арга зүй	14
6.Хяналт ба зөвлөх үйл ажиллагаа	15
- Байцаагч нарын зөвлөх ба албадах үйл ажиллагаа	15
- Хяналтын гол асуудлууд	16
7.Дэмжих үйл ажиллагаа	18
- Үндэсний компанит ажил	18
8.Үйлдвэрт явуулж буй шууд дэмжлэг	19
- Удирдлагад дэмжлэг үзүүлэх	19
- Удирдлага ба ажилчдын хамтын ажиллагаа	20
- Урьдчилан сэргийлэх арга хэмжээ	20
9.Сургалт ба мэдээлэл	22
- Удирдлагын сургалт	22
- Шинэ ажилчдын болон давтан сургалт	23
- Зааварлагч нарын сургалт	23
10.Ижил үйлдвэрлэл-өргөн хүрээтэй хамтын ажиллагаа	25
- "Хамгийн сайн" туршлага солилцох	26

1. ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ БА ХАМАРЧ БУЙ ХҮРЭЭ

Ази, номхон далайн орнуудад эдийн засгийг дэмжих арга зам - нь хөдөө аж ахуй болон тэргүүлэх үйлдвэрлэлийг илүү хэмжээтэй хөгжүүлэх явдал гэж үзэн уг асуудалд өндөр ач холбогдол өгч байна. Сүүлийн үед шинэ технологийн зэрэгцээ гадаад орны техник, тоног төхөөрөмж, технологи өргөн нэвтэрч байгаа нь ажилчдын аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн болон хөдөлмөрийн нөхцөлд олон талаар нөлөөлөх боллоо. Урьд нь хийж гүйцэтгэж байгаагүй олон төрлийн шинэ ажлууд хийгдэх болсон нь мэргэжил эзэмшээгүй ажилчдын хувьд үйлдвэрийн осолд өртөх, мэргэжлээс шалтгаалах өвчинд нэрвэгдэх зэрэг таагүй орчныг бүрдүүлж байна. Хөдөө орон нутгаас хот суурин газарт олноороо шилжин суурьшиж шинэ орчин нөхцөлд хөдөлмөр эрхлэх болсон ажилчдын хөдөлмөр хамгааллын асуудал хүндрэлтэй байна.Газар зүйн тархацын хувьд өргөн уудам нутагт байршсан жижиг, дунд үйлдвэрт ажиллагсадын хөдөлмөрийг хамгаалах асуудлыг зохион байгуулах, биелэлтэнд хяналт тавихад их бэрхшээл учирч байна.

Өнөөгийн техникийн дэвшлийг үл харгалзан ослын хувь, хэмжээ барилга, уул уурхай, тээвэр аж үйлдвэр, газар тариалан болон ойн салбарт өндөр байна. Эдгээр салбаруудад хүний амь үрэгдүүлсэн болон бусад янз бүрийн ослын хэмжээ их байгаа нь эрсдэл өндөртэй ажлын нөхцөл болон хийхэд төвөгтэй цогцолбор ажил их байдагт оршино. Олон орны барилгын салбарт хүний амь үрэгдүүлсэн ослын тоо өндөр байгаа нь өндөрт ажилладаг, ажил нь үргэлж солигдож байдаг, дадлага туршлагагүй хүнийг ажиллуулж байгаатай холбоотой байна. Уул уурхай, тээвэр, хөдөө аж ахуй, ойн салбарт эрсдэл өндөр байгаа нь хөдөлмөрийн зохион байгуулалт муу, ажил нь тогтмол солигдож байдагтай холбоотой. Олон үйлдвэрүүдэд ажилчид нэг ажлыг байнга давтан хийх, химийн бодис, дуу шуугиан, доргиотой газар ажилладагаас шалтгаалан эрүүл мэндээ хохироох явдал их гарч байна. Ихэнх үйлдвэрлэлийн осол нь үйлдвэрлэлийн өндөр эрсдэлд тохирсон хамгаалах арга хэмжээ дутагдалтай байгаагаас шалтгаалж байгаа юм. Эдийн засгийн шинэчлэлтийг хийхдээ ихэвчлэн нийгмийн эмзэг хэсэг, хөдөлмөр эрхлэгч хүүхдүүдийн хөдөлмөр хамгааллын асуудлыг шийдэхгүйгээр явуулдаг нь нийгмийн сөрөг үр дагавартай байдаг. Бүс нутгийн тайлангаар осол ба өвчлөлийн эдийн засгийн өртөг нь ажиллах хүчний нийт өртөгийн 2-3 хувь байна.

Ази, Номхон далайн бүсэд нийтлэг буй хөдөлмөрийн хүнд нөхцөл бүхий ажлын хэлбэрүүдэд:

- газар доорхи уурхайн ажил, шугам хоолойн ажил зэрэг хөдөлмөрийн аюултай нөхцөлд хийгддэг ажлууд
- аюулгүй ажиллагааг бүрэн хангаагүй тоног, төхөөрөмж ба машин техникүүд
- химийн хортой бодис ашиглах болон түүнд өртөх ажил
- биеийн хүчний хүнд ажил
- аюул учруулж болзошгүй ажил

Үйлдвэрийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчнөөс урьдчилан сэргийлэх иж бүрэн арга хэмжээг авч хэрэгжүүлэх замаар зарим өндөр эрсдэлийг бууруулж болно гэдгийг өнөөгийн туршлага харуулж байна. Энэ нь аюулгүй ажиллагааг сайжруулахын тулд Ажил олгогч, ажилчдын хамтын үйл ажиллагааг нэгтгэх хэрэгтэй гэсэн үг юм.

ОУХБ-ын стандартууд, тухайлбал Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн тухай 1981 оны конвенц (155) болон дараа дараагийн конвенц, зөвлөмжүүдэд Эзэд, ажилчдын үйл ажиллагааны оролцоо чухал ач холбогдолтойг цохон тэмдэглэсэн бөгөөд эрсдэлийг хянах арга хэмжээ авч байхыг заасан болно. Мөн дээд удирдах даргаасаа ажлын байран дээр ажиллаж буй ажилчин хүртэлх хэмжээнд удирдан хянах, аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн систем тогтоох хэрэгтэйг сануулсан байдаг.

Бүс нутгийн хэмжээнд үйлдвэрлэлийн аюултай нөхцөл бүхий ажлын байранд дэх үйлдвэрийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар Үндэсний хөтөлбөр боловсруулах, энэ ажлыг идэвхижүүлэхэд Олон улсын хамтын ажиллагаа чухал шаардлагатай юм. Үндэсний хөтөлбөрийг аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн ерөнхий шаардлага болон тухайн нутгийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн хийх ёстой.

Энэ товхимлыг Ази, Номхон далайн бүс дэх Олон улсын хамтын ажиллагааны гарын авлага болно гэж үзэж гаргасан болно. Үүний зорилго нь үйлдвэрлэлийн аюултай хүчин зүйлээс урьдчилан сэргийлэх хөтөлбөрийг дэмжихэд оршиж байна.

Хайрцаг 1. *ОУХБ. "Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйг сайжруулах" сэдэвт Азийн бүсийн 11 дэх бага хурал. 1991 оны 11сарын 26-аас 12сарын 02. Бангкок*

Үндэсний бодлого ба хөтөлбөр гол асуудал:

- үйлдвэрлэлийн аюултай нөхцөл бүхий хөдөлмөрийн хүрээн дэх үйлдвэрийн осол ба мэргэжлээс шалтгаалах өвчнийг бууруулах
- мэргэжлээс шалтгаалах өвчнөөс урьдчилан сэргийлэх
- ажилчдыг гэнэтийн болон нийтийг хамарсан аюул, сүйрлээс хамгаалах
- бусад орноос оруулж ирсэн болон шинэ технологийн ашиглалтын аюулгүй байдал
- жижиг болон дунд үйлдвэрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн стандартыг сайжруулах
- хөдөө, тосгонд ажиллаж буй болон биеийн хүчний ажилд ажиллагсдын хөдөлмөрийн нөхцөл болон аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй, амьдрах нөхцлийг сайжруулах
- хөдөлмөр эрхэлж буй хүүхдийг хамгаалах, хүүхдийн хөдөлмөр эрхлэлтээс зайлсхийх

2. ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛТАЙ НӨХЦӨЛ БҮХИЙ АЖЛЫН БАЙРНЫ ХҮРЭЭН ДЭХ БЭРХШЭЭЛҮҮД

Үйлдвэр олонтой газар болон хөдөө тосгон, чөлөөт хөдөлмөр эрхлэгчдийн хүрээнд үйлдвэрлэлийн осол, эрүүл мэндээр хохироодог аюултай нөхцөл бүхий ажлын байр элбэг байна. Тэдэнд, хууль, дүрэм заавраар зохицуулагдсан урьдчилан сэргийлэх арга хэмжээ болон сайн дурын урьдчилан сэргийлэх хөтөлбөр шаардлагатай юм. Эрсдэл нь хөдөлмөрийн аюултай нөхцөл, аюултай ажлаас үүсэн гарч байна. Үүнд:

- өндөрт ажиллах ажил
- газар доорхи уурхайн ажил
- хөдөлгөөнт механизм бүхий машин техник буюу үйл ажиллагааны аюултай хэсэг дээр ажиллах
- химийн бодистой харьцан ажиллах ажил
- хэт дуу шуугианд ажил үүрэг гүйцэтгэх ажил
- биеийн хүчний хүнд хөдөлмөр гэх мэт.

Ихэнх эрсдэл нь хөдөлмөрийн нөхцлийн нийлмэл байдлаас шалтгаалж байгаагаас энгийн урьдчилан сэргийлэх ажил үр дүнгээ өгөхгүй байна. Жишээлбэл: өргөх тавцан дээр өндөрт гарч ажиллах үед өндрөөс унах нь өндрөөс унасан өөр биөтэд цохигдох,тоног төхөөрөмжийг бат бэх суурилуулаагүйгээс эсвэл цаг уурын тааламжгүй нөхцлөөс хамаарах зэрэг олон зүйлээс шалтгаалж болох юм. Тоног төхөөрөмж дээр ажиллахад үүсэх аюулд хортой түүхий эд материалтай харьцах, тоосжилт болон утааны нөлөө, цахилгаан гүйдэлд цохиулах болон ажил үүргийг олон дахин давтан хийх зэрэг зүйлүүд багтана. Үүнтэй нэгэн адил химийн бодис нь галын аюул, тэсэрч дэлбэрэх аюулыг багтаана.

Эрсдэлийн ийм нийлмэл хэлбэр нь эрсдэлийг тогтоож, хянах арга замыг эрж олох зайлшгүй шаардлагыг бий болгож байна.. Учирч болох бас нэг бэрхшээл нь эзэн болон ажилчдын хооронд үзэл бодлын чиглэлээр зөрөлдөөн гарч болох юм. Тэд энэ байдлыг ухамсарлах боловч засаж залруулах нөхцөл байдалд хүрч чадахгүй байгаа нь ялангуяа шинэ технологи ашиглах үед ажилчдаар технологийн туршилт, тохируулгыг хийлгэхгүй байгаагаар илэрдэг.

Жижиг үйлдвэрүүд, гэрээгээр түр ажил хийж байгаа, болон хөдөө тосгонд, биеийн хүчний ажил хийж байгаа ажилчдад энэ асуудал улам хурцаар тавигдаж байна. Олон орны аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн төвүүд өөрийн орны өргөн хүрээтэй тархсан ажлын байруудад хүрч ажиллаж чадахгүй байна. Ажил олгогч нар ихэнхдээ аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн эрсдэлийг бууруулах талаар арга хэмжээг авч чадахгүй гэж боддог. Энэ тохиолдолд хэн асуудлыг шийдэхийг чармайж байна, түүнд арга хэмжээг авч хэрэгжүүлэх нь хүнд биш гэдгийг ойлгуулж, дэмжих явдал чухал байдаг.

3. *ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БҮРЭЛДХҮҮН БА БОДИТ АЛХАМУУД*

■ *Уулзалт чухал хэрэгтэй*

Бүсийн бүх орнуудад үйлдвэрлэлийн аюултай нөхцөл бүхий ажлын байранд явуулах урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны асуудал хурцаар тавигдаж байна. Үйл ажиллагааны Үндэсний хөтөлбөрт ойрын үед авч хэрэгжүүлэх арга хэмжээ, бодит алхамуудыг авч үзэх ёстой. Хууль, дүрэм болон бүтэц нь бүхэлдээ үр дүнтэй арга хэмжээнд тулгуурласан байх, үр дүн бүр нь бүхэлдээ хөдөлмөрийн таатай нөхцөл нэг бүрийн үйл ажиллагаанд сайнаар нөлөөлсөн байх нь чухал. Гурван талтын зөвшилцөл нь үйл ажиллагаанд хамтын шийдвэр гаргах замаар бодит үйл ажиллагаа эхлүүлж чадна. Бодит алхамуудад:

- одоо байгаа бүтцээ хүчтэй болгох замаар бодит үйл ажиллагаа явуулах.
- үйлдвэрлэлийн осол, аюултай ажлын байранд хуулийн болон захиргаа, зохион байгуулалтын шат дараалсан арга хэмжээ авах
- үйлдвэрлэлийн үйл ажиллагааны тэргүүлэх салбарт технологийн зөвлөмж, гарын авлага мэдээлэл гаргах, сургалт, явуулах зэрэг арга хэрэглэн дэмжих үйл ажиллагааг алхам алхамаар хийх
- Эздийн ба хөдөлмөрчдийн байгууллага болон сайн дурын байгууллагын явуулж байгаа үйл ажиллагааг хүчтэй болгох
- бүсийн болон дэд бүсийн хамтын ажиллагааг дэмжих Улс орон болон, үйлдвэрийн газар бүр үйл ажиллагааны хүрээнд хийх бололцоотой алхамууд ба нэн түрүүнд хэрэгжүүлэх алхамуудыг тодорхойлох, хэрэгжүүлэх алхмаа төлөвлөх хэрэгтэй.

■ *Үйл ажиллагааны үндэсний хөтөлбөрийн бүрэлдхүүн*

Үйлдвэрлэлийн аюултай нөхцөл бүхий ажлын байранд урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа явуулах Үндэсний хөтөлбөрийн үндсэн бүрэлдэхүүнд дор дурьдсан зүйлүүд орно. Тухайн бүс нутгийн онцлогоос хамаарч дараахи зүйлүүдийн аль нэгэн хэсэгт илүү анхаарлаа хандуулж болох юм.. Үйл ажиллагааны нэгдсэн хөтөлбөр нь түүнд хамрагдах бүх асуудлыг иж бүрнээр нэгтгэн тусгасан байх ёстой.

- Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн үндэсний бодлого боловсруулах. Энэ бодлого нь товч, тодорхойгоор Засгийн газрын бодлогын нэг хэсэг нь болж тусгагдсан байх
- Засгийн газар, Эзэд, хөдөлмөрчдийн байгууллагын хооронд Үндэсний гурван талт зөвшлийн механизм болон аюулгүй ажиллагааны үндэсний гурван талт механизмыг бий болгож, баталгаажуулах. Тэдний анхаарлыг аюултай нөхцөл бүхий үйлдвэр, ажлын байр руу хандуулах
- үйлдвэрлэлийн аюултай нөхцөл бүхий хөдөлмөрийг тусгайлан зохицуулсан заалт бүхий аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн хууль, дүрмийг шат дараалсан байдлаар бий болгох. Хуулинд хамгийн бага эрсдэл бүхий ажиллах нөхцөлөөр хангахыг

Эздээс шаардсан байвал зохино. Энэ нь ажилчдын эрхийн асуудалтай холбоотой. Шаардлагатай бол аюултай нөхцөл бүхий гол үйлдвэрүүдийн тоног төхөөрөмжийг бүртгэх, аюулгүй ажиллагааны зөвшөөрөл авч байхыг тусгах, түүнд дээр ажиллах ажилчдыг тусгай сургалтанд сургаж гэрчилгээ олгож байх.

- үйлдвэрлэлийн аюултай нөхцөл бүхий газруудын аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн төрийн болон захиргааны хяналтыг хүчтэй болгох. Энэ байгууллага нь мэргэжлийн түвшинд боловсруулсан стандартуудыг мөрдүүлэх, тоног төхөөрөмжийг бүртгэх, үзлэг, ослын судалгаа хийх, тоног төхөөрөмжинд зөвшөөрөл олгох, үүнтэй холбогдсон үйл ажиллагааг дэмжих, өргөжүүлэх, мэргэжлийн зөвлөгөө өгөх, шаардлагатай үед тусгай сургалт зохион байгуулах ёстой.
- үйлдвэрийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний мэдээ, тайланг аюултай нөхцөл бүхий ажлын байрны тухай тусгай тайлбартайгаар гаргадаг механизм бий болгох. Засаг захиргаа нь тайлан гаргахад зориулж тохирох санхүүжилт хийж өгөх. Тайлан мэдээг судалж нийтэд мэдээлэх нь зүйтэй юм.
- Аюулгүй ажиллагаа эрүүл ахуйн талаар ажилладаг засгийн газрын агентлаг болон судалгааны институтуудын хянах ба зөвлөлгөө өгөх үйл ажиллагааны цар хүрээ ба хүчин чадлыг өргөжүүлэх. Эрсдлийн хүчин зүйлийг тооцох, ажлын байранд хөдөлмөр хамгааллын арга хэмжээ авах, техникийн шийдэл гаргах зэрэгт зөвлөлгөө өгөх хэрэгтэй. Мөн эздийн зүгээс явуулж буй үйл ажиллагааг дэмжих нь онцгой чухал.
- эзэд ба ажилчдын зүгээс үйлдвэрлэлийн аюултай нөхцөл бүхий хөдөлмөрийн талаар явуулсан аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн асуудлыг сайжруулах компанит ажлыг дэмжих. Хийж гүйцэтгэхэд энгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч явуулсан байх нь чухал. Энэ үйл ажиллагаа нь хөдөлмөрийн бүтээмж ба үндэсний хөгжилд тодорхой ахиц үзүүлнэ. Засгийн газар энэ үйл ажиллагааг дэмжихэд голлох үүргийг гүйцэтгэх боломжтой.
- үйлдвэрийн түвшинд аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн асуудлыг дэмжин туслах гэдэг бол маш чухал. Бүх түвшин дахь захирагч болон байцаагч нар нь илэрсэн зөрчлийг арилгуулах, эрсдэлийг арилгах арга хэмжээ авах эрхтэй байх ёстой. Үүнийг аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн мэргэжилтнүүдийн зүгээс зөвлөгөө өгөх, мэргэжлийн туслалцаа үзүүлэх замаар дэмжих ёстой юм.
- аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн сургалтын үйл ажиллагаанд хамтран ажиллах, шинэ ажилчдыг сургах сургалтын хөтөлбөрт аюулгүй ажиллагааны сургалтыг оруулах, сургалт нь өрөнхий ба онцгой аюул, урьдчилан сэргийлэх бодит арга хэмжээ, анхны тусламж, тулгамдсан үед авах арга хэмжээнүүдийг хамарсан байвал зохино
- аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн асуудлаар ажилладаг байцаагч, нарыг сургах, мэргэшлийг нь дээшлүүлэх. Сургалтанд хамрагдах байцаагч нарыг Засгийн газрын болон эзэд, хөдөлмөрчдийн байгууллага,

үйлдвэр аж ахуйн газруудын хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн ажилтнуудаас сонговол зохино.

- Урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүдийн талаар гарын авлага материалуудыг өргөнөөр гаргах
- Үйлдвэрүүдийн өргөн хүрээтэй хамтын ажиллагааг дэмжин туслах. Энэ арга хэмжээнүүдэд сургалт, мэдээлэл болон компанит ажлууд багтана.
- аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн асуудлыг сайжруулах бодит үр дүн бүхий туршлагыг харилцан солилцохыг дэмжин хөгжүүлэх. Гурван талт болон Ээзд, үйлдвэрчний байгууллагын уулзалт, семинар, сургалт их ач холбогдолтой. Үндэсний болон бүсийн мэдээллийн сүлжээ нь энэ үйл ажиллагаанд чухал үүрэг гүйцэтгэнэ.

■ *Үйл ажиллагааны хувьд голлон анхаарах үйлдвэрүүд ба хөдөлмөрийг сонгох*

Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн асуудалд нэн тэргүүнд юуг голлож ажиллах вэ гэсэн шат дараалсан төлөвлөлт хийх нь ач холбогдолтой. Онцгой анхаарал шаардах үйлдвэрүүдийг сонгох, үйл ажиллагааны өсөн нэмэгдэх байдлыг онцгойлон харгалзахыг чармайх хэрэгтэй. Энэхүү сонголтыг зөв хийх нь бусад үйлдвэрлэлийн аюултай нөхцөл бүхий хөдөлмөрийг арилгахад тус дөхөм болно. Голлон анхаарах салбар, үйл ажиллагааг сонгоход дараах шалгуурыг авч үзнэ:

- үйлдвэрийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчинд илүү өртөх байдал
- тухайн салбар буюу үйл ажиллагаа нь үндэсний эдийн засгийн хөгжилд үзүүлэх нөлөө, ач холбогдол
- улс орны хэмжээнд аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн асуудлыг сайжруулах, хөгжүүлэхэд эзлэх багтаамж
- аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн үндэсний бодлогын хүрээнд орох боломж

■ *Бодит алхамууд*

Аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн асуудлаар Финляндаас санхүүжүүлж буй Ази, Номхон далайн бүсийн хөтөлбөр хэрэгжиж буй орнуудын өнөөгийн туршлагаас харахад үндэсний болон үйлдвэрлэлийн өргөн хүрээн дахь аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн асуудлын үр дүнтэй болгох алхам нь гурван талын зохицуулалт болох нь харагдаж байна.

Үйл ажиллагааны хөтөлбөрийг төлөвлөх, дэмжихэд дор дурдсан бодит алхамууд орно.

Алхам 1. Үйлдвэрийн осол мэргэжлээс шалтгаалсан өвчин, аюулгүй ажиллагааны үндэсний статистик, эрүүл ахуйн асуудлын талаарх өнөөгийн байдлын тухай мэдээлэл цуглуулах

Алхам 2.Үйлдвэрлэлийн аюултай нөхцөл бүхий хөдөлмөрөөс урьдчилан сэргийлэх асуудлыг үндэсний хөгжлийн хөтөлбөрийн нэг хэсэг болгон боловсруулах

Алхам 3. Голлон анхаарах салбар болон үйл ажиллагааг сонгох

Алхам 4. Зөвшилцөх механизмын үндсэн дээр Ээзд, Үйлдвэр-

чин болон холбогдох байгууллагуудтай үйл ажиллагааг нь уялдуулах, түүнийг хэрэгжүүлэх арга боломж, сүлжээний асуудлаар зөвлөлдөх

Алхам 5. Зөвшилцөх механизмын үндсэн дээр хөтөлбөр, хуулийн хэрэгжилтэнд шат дараалсан үзлэг, хяналт шалгалт хийх

Алхам 6. Үйлдвэрийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний явцыг мэдээлэх болон үүнтэй холбогдсон ажилчдын төлберийг барагдуулах

Алхам 7. Мэргэжлээс шалтгаалсан өвчний оношийг тодорхойлох системийг бий болгох

Алхам 8. Хяналт ба мэргэжлийн зөвлөлгөө өгөх үйлчилгээг хүчтэй болгох, байцаагч нарын хяналт, мэргэжлийн зөвлөлгөө өгөх үйлчилгээг хүчтэй болгохын тулд сургалт хийх

Алхам 9.Аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн хяналтын байцаагчид болон ээзэд, хөдөлмөрчдийн байгууллагууд бусад холбогдох газруудын энэ асуудлаар ажилладаг хүмүүст сургалт, семинар хийх

Алхам 10. Аюулгүй ажиллагааны төлөвлөгөөг үндэсний болон үйлдвэрийн түвшинд:
- компанит ажил зохиох
- 3 талын сургалт семинар хийх
- үйл ажиллагааг шалгах дүгнэх гэх мэтээр бууруулна.

Алхам 11. Туршлага болон ажил дээр гарч байгаа ахиц, амжилтыг сурталчилан таниулах

Алхам 12. Үйлдвэрүүдэд технологийн шинэчлэл хийх үед аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн үйл ажиллагааны нэгдсэн төлөвлөгөөг тодорхойлох, давуу талыг нь ойлгоход нь туслах

Алхам 13. Аюултай нөхцөл бүхий ажлын байранд ажиллах ажилчин, мастер, хянагч, ээзд зэрэг бүх хүмүүсийн хөдөлмөр хамгааллын туршлага, чадварыг бүх талаар дээшлүүлэх.

Алхам 14. Үйлдвэрлэлийн ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээг сургалтын заавар, гарын авлага, хянах хуудсыг боловсронгуй болгон хангах замаар дэмжих

Алхам 15. Үндэсний аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн мэдээллийн сүлжээг байгуулах замаар мэдээллийг хурдан ашиглах, мэдээллээр хангах сувгийг бий болгох

Алхам 16. Үйлдвэрлэлийн аюултай хүчин зүйлийн хүрээнд хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн асуудлаарх тэргүүний туршлагыг солилцохын тулд семинар зохион байгуулах, ажил хэргийн уулзалт хийх, үзэсгэлэн гаргах.

■ *Нөөц бололцоо ба туршлага*

Эдгээр алхамуудыг хийхэд бодит нөөц бололцоо, туршлагаа тодорхойлж тогтоох нь чухал ач холбогдолтой. Нөөц бололцоог дайчлах, туршлага солилцоход үйлдвэр, аж ахуйн нэгжүүдийн оролцоо, үндэсний болон орон нутгийн мэргэжилтнүүд, аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн болон эзэд, хөдөлмөрчдийн байгууллагын оролцоо чухал.

Нөөц бололцоо, туршлагыг алхам, алхмаар баяжуулж байх хэрэгтэй. Үйлдвэрлэлийн аюултай хүчин зүйлийн хүрээнд гол салбараа зөв сонгох, аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн бодлогыг хэрэгжүүлэх, үр дүнг тооцох нь тус чухал.

Бүсийн болон бүс нутгийн хамтын ажиллагаа нь нөөц бололцоог дайчлах, туршлагаа солилцох болон үндэсний үйл ажиллагааг хөнгөвчлөхөд онцгой үүргийг гүйцэтгэж чадна. Тухайлбал: хамтын ажиллагаа нь чухал шаардлагатай гарын авлагыг боловсруулах, сургалт хийх, мэдээллээр хангах болон туршлагаа харилцан солилцоход онцгой үүрэгтэй.

Хайрцаг 2. *Үйлдвэрлэлийн аюултайхучин зүйлээс урьдчилан сэргийлэх Үндэсний хөтөлбөрийн бодит алхамууд.*

1. Аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн асуудлаарх өнөөгийн нөхцөл байдлын тухай мэдээлэл цуглуулах
2. Урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаарх Үндэсний бодлогыг тодорхойлох
3. Голлон анхаарах салбар, үйл ажиллагааг сонгох
4. Үйлдвэрлэлийн аюултайхучин зүйлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг үйлдвэрийн түвшинд төлөвлөх
5. Хууль болон зохицуулах дүрэм, журам стандартыг шинэчлэн боловсруулах
6. Үйлдвэрийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнийг тайлагнах, мэдээлэх үүнтэй холбогдсон ажилчдын төлбөрийг барагдуулах
7. Мэргэжлээс шалтгаалсан өвчнийг оношлох тогтолцоог хүчтэй болгох
8. Хяналт ба мэргэжлийн зөвлөгөө өгөх үйлчилгээг хүчтэй болгох
9. ХААЭА* талаар голлон ажилладаг хүмүүс болон байцаагч нарт сургалт семинар зохион байгуулах
10. Үндэсний болон үйлдвэрийн түвшинд хийж буй компанит ажлын үйл ажиллагааны нэгдсэн төлөвлөгөөг бүрдүүлэх
11. Хамгийн сайн туршлагыг сурталчлах, таниулах
12. Үйлдвэрийн доторхи шинэчлэн өөрчлөх үйл ажиллагааны ахиц, дэвшилтэй давуу талыг нь дэмжих
13. Сургалтанд бүх төрлийн нөөц, туршлагыг дайчлах
14. Сургалтыг гарын авлага, зурагт хуудас зэрэг үзүүлэн таниулах материалаар хангаж дэмжих
15. Мэдээллийг хурдан ашиглах, тараах сүлжээг бий болгох
16. Тэргүүн туршлага солилцох үйл ажиллагааг дэмжих

*** ХААЭА** - Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй

4. БОДЛОГЫН БҮТЭЦ

Үндэсний бодлого нь ажлын байрны түвшин дахь аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн удирдлагын тогтолцоог сайн зохион байгуулахтай холбоотой. Үндэсний бодлого нь үйлдвэрийн түвшинд аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн удирдлага болон урьдчилан сэргийлэх арга хэмжээг бодитой дэмжих ёстой. Энэ нь аюултай нөхцөл бүхий ажлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг тасралтгүй авч, Засгийн газраас явуулж буй бодлогыг үйлдвэрийн газрууд дэмжин хамтран ажиллана гэсэн үг юм.

Аюулгүй ажиллагааны бодлого нь Үндэсний хөгжлийн бодлогын бүрэлдэхүүн хэсэг нь болсон байх ёстой. Үүнд: аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн хууль, тогтоомж, стандартууд болон хяналт шалгалт, мэргэжлийн зөвлөлгөө өгөх ажлууд, ажлын байран дахь аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн удирдлага зохион байгуулалт, сургалт, мэдээллийн арга хэмжээ зэрэг бүх зүйл багтана.

■ *Гурван талт хамтын ажиллагаа*

Засгийн газар, Эзэд, Үйлдвэрчний байгууллагуудын хоорондын гурван талт хамтын ажиллагаа нь Үндэсний бодлого болон аюулгүй ажиллагааны хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэхэд онцгой үүрэгтэй. Гурван талт механизмын нэг бүрэлдэхүүн хэсэг нь аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн асуудал байх ёстой. Гурван талт зөвшилцлийн онцгой үүрэг нь аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн хууль болон хөтөлбөрийг хамтран гаргах, түүний хэрэгжилтийн үр дүнг хянахад оршино.

Эзэд, ажилчдыг татан оролцуулах замаар ажлын байран дахь аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн үйл ажиллагааг шаардлагын түвшинд хүргэх нь үндэсний бодлогын нэг хэсэг байвал зохино. Урьдчилан сэргийлэх арга хэмжээ нь ажлын байрны түвшинд хийгдэнэ. Эзэд аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн талаарх ажилчдын бодол саналыг дэмжих ёстой.

Аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн зөвлөлийн үүрэг нь Эзэд, ажилчдын үүрэг, хариуцлагыг тодорхойлоход орших бөгөөд Үндэсний бодлогын түвшинд тодорхой заагдсан байна. Зөвлөл нь тодорхой тооны ажилчдыг багтаасан байх ёстой. Тэд аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн үйл ажиллагааг төлөвлөх, хянахад хамтран оролцох ба энэ асуудлаар тодорхой нэмэлт санал тавьж болно. Жижиг үйлдвэрүүдийн ажлын байран дахь аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн асуудал хариуцан ажиллах төлөөлөгчийг ажилчдаар сонгуулах шаардлагатай. Хөтөлбөр бүрт ажилчдын оролцоо туйлын чухал. Ажилчид тэдэнд тулгарч болох аюул, түүнээс урьдчилан сэргийлэх талаар бүрэн мэдээлэлтэй байх эрхтэй. Тэднийг зохих сургалтанд хамруулж, ажлын байран дахь хяналтыг өөрсдөөр нь хийлгэж байвал зохино. Ажилчид нь тэдний хувьд аюултай байж болох ажил, түүнийг арилгах хамгийн дөт замыг мэдэж байдаг учир төлөвлөлт болон түүнийг хэрэгжүүлэх арга замын хүрээнд онцгой оролцогч нь байх ёстой. Үйлдвэрлэлийн аюултай нөхцөл бүхий хөдөлмөрийн хүрээн дахь аюулгүй ажиллагаа,

эрүүл ахуйн хөтөлбөр нь ажилчдын оролцоогүйгээр амжилттай сайн хийгдэж чадахгүй.

Ажилчид нь өөрсдийн эрүүл мэнд, амь насанд аюул учруулж байгаа тоног төхөөрөмжийн болон үйлдвэрлэлийн үйл ажиллагааны нөхцөл байдлыг эзэд, хянагч, байцаагч нарт түргэн мэдээлэх ёстой. Тэд эрүүл мэнд, амь насанд нь аюул нүүрлэсэн үед ажлаа зогсоож, ажлын байрнаасаа зайлж хянагч нарт мэдээлвэл зохино. Ажилчид энэ алхмыг хийснээрээ ямар нэг хариуцлага хүлээхгүй байхаар хууль дүрэмд зааж өгсөн байх хэрэгтэй..

■ *Үйл ажиллагааг хэрэгжүүлэх сонголт*

Аюулгүй ажиллагааны Үндэсний бодлогод үйл ажиллагааг хэрэгжүүлэх сонголтыг заасан байх ёстой. Материаллаг баялаг, тоног төхөөрөмж, хүний нөөц нь хязгаарлагдмал учир бүх хөдөлмөрийн хамгаалын асуудлыг нэгэн зэрэг шийдэж чадахгүй. тодорхойлж чадна. Ийм учраас үйл ажиллагаагаа хаанаас нь эхлэн явуулах ажлын дараалыг сонгох шаардлагатай болно. Эхний ээлжинд хамгийн амархан урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч, хурдан үр дүнгээ өгөх үйл ажиллагаагаар эхлэх нь ашигтай. Эдийн засгийн нөлөө бүхий үйлдвэрлэлийн өндөр эрсдлийг сонгон авч үзэх замаар шууд хэрэгжүүлэх зорилтоо зөв тодорхойлж болно. Энэ зорилтууд нь маш тодорхой байх ёстой бөгөөд хугацаа богино, хамгийн удаандаа гэхэд дунд хугацаанд хэрэгжүүлж болох зорилтууд байх хэрэгтэй

Үйл ажилагааг хэрэгжүүлэх сонголт нь жил бүр, салбар салбараар тодорхойлогдсон байх бөгөөд энэ нь нийгэм, эдийн засгийн болон технологийн хөгжил дэвшлийг тодорхойлно.

5. *ХУУЛЬ ТОГТООМЖ БА ДҮРЭМ ЖУРАМ*

Аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн ажлын байраар хангах, хяналт тавих, мэргэжлийн зөвлөгөө өгөх, эздийн хариуцлага болон ажилчдын үүрэг, үйлдвэр ба ажлын байрны түвшин дахь эзэд, ажилчдын хоорондын хамтын ажиллагааны асуудлыг заавал тусгай хууль, дүрмээр Засгийн газраас зохицуулах нь зүйтэй.

Энэ нь аюулгүй ажиллагааны өндөр түвшинд нийцсэн хууль дүрмийг боловсронгуй болгоход чухал ач холбогдолтой бөгөөд ихэвчлэн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн стандартуудаар зохицуулагдана. Үйлдвэрлэлийн аюултай нөхцөл бүхий хөдөлмөрийн хүрээнд сайн дурын арга хэмжээг дэмжихийн тулд хуульд дараах зүйлийг багтаана:

- Засгийн газар, Эзэд, Үйлдвэрчний байгууллага ажлын байрны аюулыг арилгах үйл ажиллагаанд хүлээх үүрэг, оролцоо
- ажилчдыг аюулгүй ажлын байраар хангах, аюулыг арилгах арга хэмжээг авахад Эздийн зүгээс хүлээх хариуцлага
- эзэдтэй хамтран ажиллах, аюултай ажлын тухай мэдэх, аюултай үйл ажиллагааны үед хэрхэн ажиллах сургалтын асуудлын талаарх ажилчдын эрх
- аюулгүй ажиллагаа,эрүүл ахуйн зөвлөл, аюулгүй ажиллагааны асуудал хариуцсан хүмүүсийн үүрэг
- ажлын байран дахь аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шаардлага болон хөдөлмөрийн хамгаалалд тавигдах онцгой шаардлагууд
- ажлын байран дахь аюулыг арилгах үйл ажиллагааг зохицуулах хууль тогтоомж, үр дүн бүхий дүрэм журам.

■ *Нийгмийн оролцогч талуудын үүрэг*

Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн хууль тогтоомжид аюултай ажлаас урьчилан сэргийлэх арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх, сахих талаархи Засгийн газар, ажил олгогч нар, ажилчдын үүрэг хариуцлагыг тод тодорхой зааж өгөх хэрэгтэй.

Засгийн газрын үүрэг нь хууль тогтоомж гаргахаар хязгаарлагдахгүй бөгөөд мэргэжлийн хяналтын байгууллагыг удирдан зохион байгуулж бэхжүүлэх үүрэгтэй юм.

Хууль тогтоомжоор ажлын байрны аюулгүй байдал, эрүүл мэндэд хор хөнөөлгүй байлгах талаар ажил олгогч нарын хариуцах хариуцлагыг тогтооно. Энд Малайзын хуулийн жишээг харуулав./ Хайрцаг 3./ Зарим улсад зөвхөн тодорхой хэмжээнээс илүү олон тоотой ажилчидтай үйлдвэрийн эздэд тооцох хариуцлагыг заасан байдаг. Хэдийгээр хуульд ингэж заасан ч гэсэн Засгийн газар нь аль ч ажил олгогч өөрсдийн ажилчдын эрүүл мэнд, аюулгүй ажиллагааг хариуцах талаар бүх арга хэмжээг авах хэрэгтэй. Ажил олгогч нар сайн дурааараа ажлын байранд гарч болзошгүй осол, эрүүл мэндийн

Хайрцаг 3 *Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн хууль 1994 он Малайз*

Ажил олгогч нар ба өөртөө ажлын байр үүсгэн ажиллагсдын үндсэн үүрэг

Бүх ажиллагсдын эрүүл ахуй, аюулгүй байдал, нийгмийн хамгааллыг дараахи байдлаар тодорхойлж байна. Үүнд:

- Үйлдвэр, аж ахуйн газрын аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шаадлагыг хангуулж ажиллуулах
- Үйлдвэр аж ахуйн газрууд нь бараа материалыг тээвэрлэх, хадгалах, хэрэглэхтэй холбоотой эрүүл мэндийн эрсдлээс хамгаалах ажлыг зохион байгуулах
- Ажлын байрны аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн нөхцлийг хангаж ажилчдын ажилдаа ирэх ба буцах аюулгүй байдлыг хангах
- Бүх ажиллагсдын хөдөлмөрийн нөхцлийн аюулгүй байдлыг хангаж, тэдний нийгмийн хамгааллын талаар зохих арга хэмжээг авах

ХААЭА-н талаар явуулах бодлогоо тодорхойлж, төлөвлөгөө бичиж, зорилтоо биелүүлэх арга хэмжээавч, энэ талаар бүх ажилчдын санал, дүгнэлтийг авах.

ХААЭА-н хуулийн хэрэгжүүлэхийг бусад байгууллага, хүмүүст уриалж ажиллах.

Ажил олгогч нарын хариуцлагад: тухайн аж ахуйн нэгжид ХААЭА-н бодлогоо тодорхойлох бүх ажилчдадаа танилцуулж, менежер, хянагч, ажилчдын төлөөлөгч оролцсон ХААЭА-н үйл ажиллагаа хариуцсан нэгж байгуулах үүргийг хуулиар зааж өгөх хэрэгтэй.

Хуулинд: эрүүл мэнд, аюулгүй байдалд ноцтой аюул тохиолдох үед ажилчид ямар нэг хариуцлага хүлээхгүйгээр ажлын байраа орхин гарч хянагчдаа цаг алдалгүй мэдээлэх үүрэгтэйгээр тусгах нь зүйтэй. Мөн ажилчид үйлдвэрээс явуулж буй ХААЭА-н үйл ажиллагаанд заавал оролцох, өгсөн аюулгүй ажиллагааны зааврын дагуу ажил, үүргээ гүйцэтгэх, хамгаалалтын хэрэгслийг хэрэглэх, ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээнд оролцох үүргийг зааж өгөх, ажилчид өөрийн аюултай нөхцөл бүхий ажлын талаар бүрэн мэдээлэл авч түүнээс урьдчилан сэргийлэх талаар авах арга хэмжээг мэдсэн байхаар заах ёстой.

Түүнчлэн хуулинд ХААЭА-н Зөвлөл, түүний үүрэг, хяналтын талаар заасан байх хэрэгтэй. Аль болохоор олон үйлдвэр, аж ахуйн газарт үр нөлөөтэй ажилладаг Зөвлөл байх нь чухал.

■ *Эрсдлийн хяналт*

ХААЭА-н хуулинд наад захын эайлшгүй байх нөхцлийг тусгасан байдаг. Түргэн хөгжиж байгаа технологийн хөгжил , төрөл бүрийн ажлын байрны өөр байдлаас шалтгаалж ХААЭА-н бүх асуудлыг нарийн тусгах боломжгүй байдаг.

технологийн хөгжил , төрөл бүрийн ажлын байрны өөр байдлаас шалтгаалж ХААЭА-н бүх асуудлыг нарийн тусгах боломжгүй байдаг. Тийм ч учраас хуульд хамгийн ерөнхий, зайлшгүй байх ёстой заалтууд тусгагдсан байдаг бөгөөд нарийн заалтууд нь ажлын журам, заавар гарын авлагад тусгагдсан байдаг. Хуулинд тусгагдсан байх ёстой ерөнхий зүйлүүдийн жишээнд: машин тоног төхөөрөмжийн эд ангийн хамгаалалт, аюулгүй байдал, цахилгаан тоног, төхөөрөмжийн аюулгүй ажиллагаа, аюултай химийн бодисийг хэрэглэх журам, өргөх төхөөрөмж ба усан онгоцны аюулгүй ажиллагаа, агааржуулалт, гэрэлтүүлэг, галын аюулгүй байдал, галын аюулаас гарах гарц, болон бусад нөхцөл байдал орно.

Хуулинд техник, тоног төхөөрөмж үйлдвэрлэгч, нийлүүлэгч, импортлогч, ажилдаа химийн бодис хэрэглэгчдийн үүргийг тодорхойлсон байна. Тэд техник, тоног төхөөрөмж, химийн бодисийн аюул, түүнээс хамгаалах талаар хэрэглэгчдэд мэдээлсэн байх ёстой. Химийн бодис нийлүүлэгч нь химийн бодисийн аюулгүй байдлын зааврыг хамт нийлүүлэх хэрэгтэй.. Хууль нь шинэ технологи оруулж ирэхэд маш чухал үүрэг гүйцэтгэдэг.

■ *Урьдчилан сэргийлэх тусгай арга хэмжээ*

Хуулинд аюултай ажлын байранд урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах тухай заалтууд болон хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, үйлдвэрлэлийн эрүүл ахуйн талаар тусгай онцлогтой ажлын байр ба энэ ажлын байранд шаардагдах зайлшгүй урьдчилан сэргийлэх арга хэмжээг тодорхойлох нь зөв юм.

Тусгай арга хэмжээнд:

- Тухайн ажлын байранд ажилладаг ажилчдад зориулсан аюулгүйн стандарт
- Ажилчдын эрүүл мэндийн үзлэг ба эрүүл мэндийг нь хамгаалах арга хэмжээ
- Ажлын байрны ХААЭА асуудлыг хариуцан ажиллах хүмүүсийг сонгон шалгаруулж томилох
- Ажилчдыг хөдөлмөр хамгааллын асуудлаар сургаж, танилцуулах
- Үйлдвэрийн хэмжээнд ХААЭА-н ажиллагааг туслан дэмжих үйл ажиллагаа орно.

■ *ХААЭА-н удирдлага, зохион байгуулалт*

Хуулийг үрдүнтэй хэрэгжүүлэх нь ХААЭА-н үндэсний хэмжээн дэх удирдлага, захиргааны чадвараас хамаарна.

Захиргаа нь:

- Байцаагчдаараа дамжуулан бүх боломжит арга хэмжээг явуулах.
- Үйлдвэрлэгчдийн явуулсан техник тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагаа, хамгаалах хэрэгслийг үр нөлөөтэй ашигласан байдлын талаарх арга хэмжээг дүгнэн гаргах
- ХААЭА-н асуудал дээр ажиллах хүмүүсийг сонгон шалгаруулж эрхийн гэрчилгээ олгох
- Үйлдвэрлэгч нарт техникийн үйлчилгээ явуулахад нь туслах
- Хэрэгцээт сургалт, семинарыг зохион байгуулах
- ХААЭА-н асуудлаар ажиллаж буй сайн дурын байгууллагуудын үйл ажиллагааг дэмжих

Засаг захиргааны нэг гол үүрэг нь бүх аюултай ажлын байртай холбоотой мэргэжлээс шалтгаалах өвчлөл ба ослын

судалгаа гаргаж тайлан хөтлөх явдал юм. Нийгмийн хамгааллын алба ба үндэсний статистик, ослыг тодруулан судлах агентлагуудын үйл ажиллагааны уялдаа холбоо нь чухал юм. Олон удаа байнга давтагддаг осол, мэргэжлээс шалтгаалах өвчинг илрүүлж тогтоох нь түүнээс урьдчилан сэргийлэх ямар арга хэмжээ явуулахыг шийдэхэд чухал хүчин зүйл болно. Их аюултай ба том хэмжээний ослыг тогтоох комиссийг хэрхэн байгуулах талаар хуульд заасан байх хэрэгтэй.

Мэргэжлээс шалтгаалах өвчлөлийг оношлон тогтоох алба байгуулж, мэргэжлээс шалтгаалах өвчлөлийн улсын хэмжээнд жагсаалт гаргаж үүнийгээ шинэчлэн сайжруулан баяжуулж байх нь чухал. Эмнэлгийн мэргэжилтэнүүдэд мэргэжлээс шалтгаалах өвчлөлийг оношлох явцад туршлага дутуугаас буруу оношлох явдал тохиолддог. Тухайн өвчлөлийг хуулинд зааснаар мэргэжлээс шалтгаалах өвчлөл үү, үгүй юу гэдгийг тогтоох алба байх хэрэгтэй юм. Эмнэлгийн ажилтангуудыг оношлогооны техник дээр ажиллуулах талаар сургалт явуулах нь чухал. Энэ асуудал дээр маргаантай асуудал гарах үед түүнийг зохицуулах аргачлалтай байх хэрэгтэй. Үйлдвэрлэийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчлөлд тэтгэлэг өгдөг тогтоц нийгмийн хамгааллын системд байх хэрэгтэй. Улсын хэмжээнд ажилчдад тэтгэлэг өгдөг даатгалын систем байгуулах хэрэгтэй. Ослын ба мэргэжлээс шалтгаалах өвчлөлийн тайлангийн тогтолцоо нь тэдгээрийг оношлон тогтоох тогтолцоотой харилцан уялдаатай байх хэрэгтэй. Энэ уялдаа холбоо нь осол ба мэргэжлээс шалтгаалах өвчлөлийг тогтоох асуудал дээр маргаан үүссэн тохиолдолд үүнийг зохицуулах ерөнхий зарчмыг тогтооно.

■ *Стандарт ба арга зүй*

Ажил олгогч ба ажилчдын идэвхитэй дэмжлэгтэйгээр ХААЭА-н сайн дурын байгууллага үүсэх хандлага өсч байна. Олон улсын хөдалмөрийн байгууллагын Зөвлөмж, конвенцоор энэ талаар чухал баримт бичгүүд гаргаж байна. Үүнд:

- Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн конвенц (№ 155) ба Зөвлөмж (№164) 1981 он.
- Үйлдвэрлэлийн эрүүл ахуйн үйлчилгээний конвенц (№161) ба Зөвлөмж (№ 171) 1985 он.
- Азбестийн конвенц (№162) ба Зөвлөмж (№172) 1986 он.
- Барилга дэх аюулгүй ажиллагаа ба эрүүл ахуйн конвенц (№ 167) ба Зөмлөмж (№175) 1988 он.
- Химийн бодисийн конвенц (№170) ба Зөвлөмж (№ 177) 1990 он.
- Шөнийн хөдөлмөрийн конвенц (№171) ба Зөвлөмж (№178) 1990 он.
- Гол үйлдвэрлэлийн ослын санамжийн тухай конвенц (№174) ба Зөвлөмж (№181) 1993 он.

Улсын хэмжээний дүрэм журам нь ерөнхийдөө эрсдлийг үнэлэх, түүнээс хамгаалах, тухайн салбарын ажилд зориулагдсан байдаг. Одоо мөрдөж байгаа олон улсын дүрэм, журам нь улс, үндэстэнгүүдийн журам, арга зүйг хөгжүүлэх суурь нь болж өгдөг.

6. ХЯНАЛТ БА ЗӨВЛӨХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Хяналт нь хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, хууль дүрмийн хэрэгжилтийг шалгахад чухал үүрэг гүйцэтгэдэг. Хөдөлмөрийн хяналтын байцаагч /зарим оронд үйлдвэрийн байцаагч гэж нэрлэдэг/ нарын албан тушаалын эрх, гүйцэтгэх үйл ажиллагаа нь хуулинд маш тодорхой тусгагдсан байх ёстой. Хуулинд байцаагч нар шаардлага тавих, торгууль ноогдуулах, торгууль ба шаардлагыг буцааж татах зэрэг зүйлүүдийг тусгасан байх ёстой. Үйлдвэрлэгч нарт зөвлөлгөө өгч, хуулийн дагуу ажиллуулах чадвартай олон тооны байцаагчтай байх нь маш чухал.

Үйлдвэрлэгчдээс хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн урьдчилан сэргийлэх хяналтын ба зөвлөх үйл ажиллагааг дэмжих хэрэгтэй. Үүнд:

- Ажлын байрны аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн эрсдлийг хянах, бууруулах талаар хийж байгаа ажил олгогч ба ажилчдын үйл ажиллагааны идэвхи зүтгэлийг урамшуулах
- Аюулын хэмжээнээс хамааарч хөдөлмөр хамгааллын үйл ажиллагаагаа өндөрсгөх
- Тодорхой нөхцөлд боломжтой анхааруулах техник хэрэгсэл, дохиолол, гарын авлагаар хангах
- Ажил олгогч, хянагч болон ба эрсдэл үнэлэхэд оролцдог ажилчдад сургалт, семинар зохиох
- Өөр үйлдвэр, салбарын дэвшилтэт туршлагыг харилцан солилцож нэвтрүүлэхийг ихэсгэх

■ *Байцаагч нарын зөвлөх ба албадах үйл ажиллагаа*

Хяналтын үйл ажиллагаа иж бүрэн, төвлөрсөн байдлаар зохион байгуулагдсан байх хэрэгтэй. ХААЭА-н хяналтын үйл ажиллагаа нь хөдөлмөрийн хууль, тогтоомжийн биелэлтийг хангуулах хяналт шалгалтын нэг хэсэг байна. Хяналтын байцаагч нарын үйл ажиллагаа нь ямар улсад, ямар агентлагийн байцаагч вэ гэдгээс хамаарч өөр өөр байдаг. Зарим оронд хөдөлмөрийн байцаагч нар нь хөдөлмөрийн бүх асуудал, түүнд багтаан ХААЭА-н бүх хяналтыг тавих эрхтэй байдаг. Гэтэл зарим улсад хөдөлмөрийн байцаагч нар нь хөдөлмөрийн ерөнхий нөхцлийг шалгаж, ХААЭА-н байцаагч нар зөвхөн ХААЭА-н нөхцлийг шалгадаг.Шугам хоолой, уурхай, тэсрэх бодис, мэргэжлээс шалтгаалах өвчлөл, үйлдвэрлэлийн эрүүл ахуй зэргийг шалгадаг тусгай байцаагч нар байж болно. Тухайн үйлдвэр, аж ахуйн газрыг иж бүрэн бүх талаас нь /түүний дотор ХААЭА-г оролцуулан/ шалгах нь чухал. Учир нь ХААЭА асуудал нь үйлдвэрийн менежментийн салшгүй нэг хэсэг юм.

Хэрвээ хөдөлмөрийн байцаагч нь ХААЭА үндсэн шаардлагыг шалгадаг, ХААЭА байцаагч мөн хөдөлмөрийн үндсэн нөхцлийг давхар шалгадаг байвал маш их ач холбогдолтой болно. Байцаагч нар шалгалтынхаа явцад олон асуудлыг зэрэг шалгаж байвал цөөн тооны байцаагчаар олон үйлдвэр аж ахуйг шалгах бололцоо олгоно. Төвлөрсөн хяналтын систем

нь улс үндэстний хэмжээнд тавигдаж буй шаадлагаас хамааран хөгждөг.

Хяналтын үйл ажиллагааны аргачлал, нөхцөл нь хуулинд тусгагдсан байх ёстой. Үүнд хөдөлмөрийн аюултай нөхцөл бүхий тоног төхөөрөмжийн бүртгэл, үйлдвэр шинээр байгуулахад оролцох байцаагч нарын үүрэг, хянах үйл ажиллагаа, мэргэжлийн ур чадвар ,тайлан бүртгэл, зөрчлийг илрүүлэн тогтоох, бусад зайлшгүй шаардлагатай аргачлал, журам зэргийг багтаасан байх ёстой.

Байцаагч нарын нэг гол үүрэг бол үйлдвэрлэгчдийг техникийн зөвлөмжөөр хангах явдал юм. Тоног төхөөрөмжийн аюулгүй байдал, эрүүл мэндийн эрсдэл, хортой химийн бодисийг хэрэглэх аюулгүй байдал, аюултай физик хүчин зүйл, хамгаалалтын хэрэгслийг нэвтрүүлэх зэрэгт зөвлөлгөө өгөх хэрэгтэй. Байцаагч нар нь хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах бүх арга хэмжээ авагдсны дараа хувийн хамгаалах хэрэгсэл хэрэглэх асуудлаар үйлдвэрүүдийг удирдан чиглүүлэхэд гол үүрэг гүйцэтгэдэг. Мөн тэд байгаль орчны болон ажлын байрны аюулгүй байдал, эрүүл ахуйн хөтөлбөрийг хөгжүүлэх, хянахад дэмжлэг үзүүлж болно.

■ *Хяналтын гол асуудлууд*

Учирч болзошгүй ноцтой аюулыг зайлуулах нь хяналтын хамгийн гол асуудал юм. Учирч болзошгүй ноцтой аюул гэдэг нь ажилчдад эсвэл иргэдэд ноцтой аюултай буюу үхэлд хүргэж болзошгүй аюул оршин байгаа нь мэдэгдэж буй бүх нөхцлийг хэлнэ. Ажил олгогч, ажилчид өдөр тутмын ажлын явцад учирч болзошгүй ноцтой аюулыг илрүүлэх ёстой. Ердийн шалгалтын явцад иймэрхүү аюулыг илрүүлэн тогтоох талаар байцаагч нар сайн бэлтгэгдсэн байвал зохино.

Хуулинд аюултай нөхцөл бүхий ажлын байранд ХААЭА-н менежентийг сайн зохион байгуулах нь маш чухал. Эдгээр ажлын байранд хуулийн дагуу ХААЭА-н асуудал хариуцсан хүн байгаа эсэх, тэр хүмүүс ямар төлөвлөгөө зохиож, юу гүйцэтгэж байгааг шалгах замаар үүнийг үр өгөөжтэй хэрэгжүүлж болно.

ХААЭА-н менежментийг стандартын дагуу зохион байгуулахын хамт ослыг бүртгэх, тайлагнах асуудал дээр анхаарлаа төвлөрүүлэх нь үр дүнгээ өгнө. Байцаагч нар эзэд ба ажилчдын төлөөлөгчийн хамт тайланг шалгаж, том ослын шалтгааныг тогтоосон актыг хянаж байх хэрэгтэй.

Дараагийн гол асуудал бол хөдөлмөрийн аюултай нөхцөл бүхий тоног төхөөрөмжийн ашиглалт ба үйлдвэрлэлийн процессийн явц дахь аюулгүй ажиллагаа юм. Хууль, дүрмээр аюулгүй ажиллагаа хариуцсан ажилтан байхаар тусгагдсан байвал энэ ажилд байгаа хүний мэргэжлийн ур чадвар, шаардлагатай сургалтанд хамрагдсан эсэхийг зайлшгүй шалгах хэрэгтэй. Хуулинд заагдаагүй бусад машин, тоног төхөөрөмжийн хувьд бол эдгээр ажлын байранд ажиллаж буй ажилчид ХААЭА-н сургалтанд хамрагдсан эсэхийг шалгах хэрэгтэй.

Машин тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагааны тухай анхааруулах мэдээлэл нь ажлын байрны өдөр тутмын менежментийн нэг хэсэг байх ёстой. Ажил олгогч нар ажлын байрны машин тоног төхөөрөмж бүрийн техникийн бүтэц зохион байгуулалт ба аюулгүй

ажиллагааны талаар анхааруулж, мэдээлэх үүрэгтэй. Байцаагч нар энэ арга хэмжээний үр дүнг шалгаж байх хэрэгтэй.

Эзэд ХААЭА-н талаар үйлдвэрт явуулсан сургалт, энэ асуудалтай холбогдсон үйл ажиллагааны талаар байцаагчдад мэдээлж байх үүрэгтэй. Ялангуяа шинээр ажилд орсон ажилчдыг сургасан, хуучин ажилчдаа давтан сургасан тайлан хадгалагдсан байх ёстой.

Байцаагч нар нь аж ахуйн нэгжийн ХААЭА-н зөвлөлийн үйл ажиллагааны үр дүнг шалгах хэрэгтэй. Үйлдвэр, аж ахуйн нэгжийн ХААЭА-н өөрийгөө хөгжүүлэх хөтөлбөр, түүний хэрэгжилт нь энэ асуудлыг хариуцаж буй удирдлагын арга хэмжээний тайлан болно.

Хяналтын эдгээр асуудлыг хяналт хийж байх явцдаа шинэ зүйлээр баяжуулж байх ёстой. Хяналтын гол зорилго нь хууль, тогтоомжийн хэрэгжилтийг шалгадаг боловч зарим тохиолдолд зөвлөлгөө өгөх зорилгоор хийгддэг.

7. ДЭМЖИХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шаардлага нь зарим улсад муж болгонд харилцан адилгүй байдаг. Зарим улсууд хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн дэд бүтцээ маш тодорхой байгуулсан байхад зарим улсууд үндэсний бодлого, хөтөлбөртөө ХААЭА-н үндсэн зарчмуудыг тусгаагүй байдаг. Засгийн газар, эзэд, үйлдвэрчний байгууллагын хамтарсан гурван талт үйл ажиллагаа нь үндэсний ба үйлдвэрийн хэмжээнд гол үүрэг гүйцэтгэдэг.

Дэмжих үйл ажиллагааны зорилго нь үндэсний ба үйлдвэрийн хэмжээнд ажлын байрны ХААЭА-н нөхцлийг тогтоон хамгаалах явдал юм. Үүнд гол нь:

- Бүх ажлын байрны, ялангуяа хөдөлмөрийн аюултай нөхцөл бүхий ажлын байрны ХААЭА-н шаардлагыг хэвлэн нийтлэх
- Үндэсний хэмжээнд компанит ажлыг тогтмол зохион байгуулах. / Жишээ нь: Аюулгүй ажиллагааны 7 хоног гэх мэт/
- Тухайн салбарын тодорхой чиглэлд ХААЭА-н мэдлэгийг дээшлүүлэх ажлыг зохион байгуулах
- Ажлын байртай холбогдсон ослоос хамгаалах практик туршлагыг харилцан солилцохыг дэмжин урамшуулах.

■ *Үндэсний компанит ажил*

ХААЭА-н компанит ажлыг үндэсний хэмжээнд зохион байгуулах нь их ач холбогдолтой. Эдгээр компанит ажилд жил бүрийн аюулгүй ажиллагааны долоо хоног, ХААЭА-н хурал зөвлөлгөөнүүд, аюулгүй ажиллагааг сайн хангасан үйлдвэр аж ахуйг шагнан урамшуулах, олон түмэнд аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн талаар сурталчилах, мэдээллийг нийтэд тараах зэрэг орно.

Энэ компанит ажлын үед бэлэн уншиж хэрэглэх материалаар хангах явдал нь онцгой байр суурь эзэлдэг. Эдгээр гарын авлага, материал нь ажил олгогч болон ажилчдын дунд аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн үр өгөөжийг дээшлүүлэх, ослын эрсдлийг багасгах, зайлуулах, осол ба мэргэжлээс шалтгаалах өвчлөлөөс урьдчилан сэргийлэхэд чухал нөлөө үзүүлнэ. Гэхдээ зардал багатай, практикийн ач холбогдолтой шийдвэрийг сонгох хэрэгтэй.

Эдийн засгийн хөгжил, хөдөлмөрийн бүтээмж, хөдөлмөрийн нөхцлийн хоорондын уялдаа холбоог бий болгоход дэмжих үйл ажиллагаа чиглэгдсэн байх хэрэгтэй. ХААЭА-н сайн менежмент нь бизнессийн практикийн нэг хэсэг гэдгийг энэ үйл ажиллагаагаар үзүүлэх хэрэгтэй.

8. ҮЙЛДВЭРТ ЯВУУЛЖ БУЙ ШУУД ДЭМЖЛЭГ

Улс орнууд үйлдвэр, аж ахуйн нэгжийн түвшинд ХААЭА-н удирдлага, зохион байгуулалтыг сайжруулах шаардлагатай байгааг тодорхой хэмжээгээр ойлгож байна. Үйлдвэр, аж ахуйн нэгжийн түвшин дэх үйл ажиллагааг шууд дэмжих дэмжлэгт дараахи арга хэмжээнүүд орно.

- Ажлын байранд дахь осол , ХААЭА-н арга хэмжээ, хариуцлагыг тодорхойлох
- Ослыг эрсдлийн хэмжээнээс нь хамаараруулан урьдчилан сэргийлэх ажил зохион байгуулах
- Ажиллах орчин, эрүүл ахуйн нөхцөлд тогтмол шалгалт явуулж байх
- Техникийн талаар эрүүл мэндэд хор нөлөөгүй боломжийн шийдлийг тодорхойлох
- Ажлын байрны ХААЭА талаар гарч буй эрэг хандлагыг дэмжих, менежер, байцаагч, ажилчдад сургалт явуулах.

■ *Удирдлагад дэмжлэг үзүүлэх*

Үйлдвэр, аж ахуйн нэгжийн ХААЭА-н хөтөлбөр нь үйлдвэрийн дээд удирдлагын идэвхитэй дэмжлэгтэйгээр эхлэх ёстой. Ажлын байрны ХААЭА-г зөв зохион байгуулагдсан удирдлагагүйгээр урьдчилан сэргийлэх ямар ч арга хэмжээ авах боломжгүй юм. Ажилчдын аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн хариуцлагыг аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны нэг хэсэг гэдгийг хүлээн зөвшөөрөх нь удирдлагатай холбоотой. Энэ нь бас үйлдвэрийн бусад гишүүдийн энэ талаархи мэдлэгийг дээшлүүлэх хариуцлагыг давхар хүлээн зөвшөөрч байна гэсэн үг юм. Удирдлагын бүх төлөөлөгч нар ХААЭА-н асуудлаар өөрсдийнхөө саналаа гаргах ёстой.

Удирдлага нь ажилчдын ХААЭА-н талаар үйл ажиллагааны тунхаглал гаргах хэрэгтэй. Энэ тунхаглал удирдлагын ба ажилчдын бүх түвшинд танилцагдсан байх ёстой. Энэ тунхаглалаар ХААЭА талаархи үйлдвэрийн зорилгыг гарган үзүүлж, үүнийг хэрэгжүүлэхэд дээд удирдлага, гүйцэтгэх удирдлага, хянагч нар болон ажилчид тус тусдаа ямар хариуцлагатайг тусгасан өгнө. Тунхаглал нь үйлдвэрийн ХААЭА-н хөтөлбөрийн тулгын чулуу болох ёстой. Ажил олгогч, дамжлагын мастер, ХААЭА хариуцсан ажилтангуудад сургалт явуулах үед тунхаглалыг ойлгуулах асуудлыг дэмжих хэрэгтэй.

Хууль, дүрэм, үндэсний хөтөлбөр, үндэсний ба орон нутгийн чанартай бүх арга хэмжээнд эздийн ХААЭА-н талаар хүлээх хариуцлага дээр дэмжлэг үзүүлэх хэрэгтэй. Үйлдвэрийн дээд удирдлага нь ХААЭА асуудлаар дэмжин туслах үйл ажиллагаандаа дараахи зүйлүүдийг анхаарах нь зүйтэй.

- Үйлдвэрийн ХААЭА хөтөлбөрт удирдлагын удирдан чиглүүлэх үүргийг тодорхой тусгаж өгөх
- Үйлдвэр, машин, тоног төхөөрөмжийн дизайн, хэрэглээнд аюулгүй ажиллагааг тусгах
- Аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн талаар сайн бэлтгэгдсэн хянагч нарыг томилох

- Ажилчдын дунд аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шаардлагыг сахиулах талаар тодорхой ажил зохион байгуулах
- Үйлдвэрийн осол ба өвчлөлийг бүртгэж,тэдний шалтгааныг тогтоож , хамгаалах арга хэмжээг тодорхойлох
- ХААЭА-н талаар явуулж буй үйл ажиллагаандаа дүгнэлт хийж осол ба өвчлөлөөс хамгаалах арга хэмжээ зохион байгуулах
- Хөдөлмөрийн гэрээний дагуу удирдлагын үүргийг тодорхойлох
- Аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн асуудлыг удирдах зорилгоор уулзалт, зөвлөлгөөн тогтмол зохион байгуулах

■ *Удирдлага ба ажилчдын хамтын ажиллагаа*

Үйлдвэрийн удирдлага нь ажилчдын дагаж мөрдөх ХААЭА-н дүрэм, зааврыг хийж өгөх ёстой. Ажилчид ХААЭА-н арга хэмжээг өөрийн ажлын нэг хэсэг гэж ойлгох ёстой юм. Ажилчдын үүрэг нь:

- Үйлдвэрийн ХААЭА-н дүрмийг дагаж мөрдөх
- Өөрсдийн ажилтай холбогдсон аюултай нөхцөл бүхий хөдөлмөр, түүнээс урьдчилан сэргийлэх, анхны тусламж үзүүлэх талаар сургалтанд хамрагдаж заавар авсан байх
- Ажил олгогчоос өгсөн хамгаалах хэрэгсэл, аюулгүй ажиллагааны хувцсыг өмсөж хэрэглэх
- Хянагч болон байцаагчдад хөдөлмөрийн аюултай нөхцөл бүхий тоног төхөөрөмжийн талаар мэдээлэх
- Үйлдвэрийн осол гарсан үед байцаагчид мэдээлэх, эмнэлгийн анхны тусламж үзүүлэх
- Үйлдвэрээс зохион байгуулж буй ХААЭА-н арга хэмжээнд оролцох.

Үйлдвэрийн хэмжээнд зохион байгуулж байгаа ХААЭА-тай холбоотой үйл ажиллагаа нь ажилчдын идэвхитэй оролцоотойгоор явагдах ёстой. Энэ нь мөн ХААЭА-н зөвлөл, ажилчдаас сонгогдсон хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны төлөөлөгч нар, менежер, хянагч нарын өдөр тутмын харилцааг идэвхижүүлдэг сайн талтай.

Хэрвээ үйлдвэрлэл дээр маш осолтой ажлын байр байгаа бол ХААЭА Зөвлөл байгуулах зайлшгүй шаардлагатай. Энэ Зөвлөлд удирдлага ба ажилчдын аль алинаас нь төлөөлөгч орсон байх хэрэгтэй. Зөвлөл нь тогтмол хуралдаж ХААЭА-н хөтөлбөр, осол, өвчлөлийг шалган тогтоосон тайлан, ажилтай холбоотой яаралтай хэрэгжүүлэх урьдчилан сэргийлэх арга хэмжээ зэргийг хэлэлцэх хэрэгтэй.

■ *Урьдчилан сэргийлэх арга хэмжээ*

Аюултай нөхцөл байдал бий болсон тохиолдолд урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах нь онцгой ач холбогдолтой. Ийм үед эзэд ба ажилчид хамтран сургалт хийх, мэдээлэл солилцох үйл ажиллагаа зохион байгуулах нь энэ асуудлыг тодорхойлох хамгийн тохиромжтой хэлбэр юм. Хэдийгээр хууль дүрэм чухал ч гэсэн тухайн тохиолдолд тохирох практик үйл ажиллагааг дэмжих хэрэгтэй.

Хайрцаг 4. *Барилгын салбар дэх хөдөлмөрийн аюултай нөхцөл бүхий ажил дээр авах практик арга хэмжээ*

Японы барилгын компанийн дотоод дүрмийн хэсгээс.

- Салбар бүрээр ХААЭА-н чиглэлээр удаан хугацааны удирдлагын бодлого ба жилийн төлөвлөгөөг хийнэ.
- Хэсгийн менежерүүд нь ХААЭА-н гол анхаарах асуудлуудыг тодорхойлж жилийн төлөвлөгөө хийнэ.
- Хэсгийн захирал нь хэсгийн ХААЭА-н удирдлагыг толгойлно.
- Салбар ба барилгын хэсэг бүр өөрийн ХААЭА-н Зөвлөл байгуулна. / 5-аас доош ажилчинтай хэсэг нь Зөвлөл байгуулах эсэхээ өөрсдөө шийдэж болох боловч хэсгийн ХААЭА-г хариуцсан төлөөлөгч байна. /
- Үйл ажиллагаа явуулж буй газар болгонд ХААЭА-н ерөнхий хянагч , хэсгийн хянагч, үйлдвэрийн эмч томилогдсон байна.
- Ажиллаж буй байр бүрт аюулгүй ажиллагаа хариуцсан тохирох хүнийг тухайн хэсгийн ахлагч томилно.
- Барилгын ажлын хэсэг болох ХААЭА-н төлөвлөгөөг тусгай зөвлөл судалж батална.
- Хэсгийн ХААЭА-н асуудал эрхэлсэн ажилтан нь тоног төхөөрөмж, хөдөлмөрийн нөхцөл, ажлын аргачлалыг төлөвлөгөөны дагуу шалгана.
- Хэсэг бүрт өөрсдийн ажлын төлөвлөгөөний дагуу ХААЭА талаар сургалт зохион байгуулна.
- Жил бүр ХААЭА-н талаар сайн ажилласан салбарыг шалгаруулж урамшуулна.

9. СУРГАЛТ БА МЭДЭЭЛЭЛ

Аюултай нөхцөл бүхий үйлдвэрлэлийн үндэсний бодлогын чухал хэсэг нь сургалт, мэдээллийн үйл ажиллагааг дэмжих явдал нь юм. Сургалтын хөтөлбөр нь аюултай нөхцөлд ажиллаж буй ажилчид, эзэд, захирагч болон хянагч нарыг хамруулахаар байх ёстой. Аюулгүй ажиллагаа эрүүл ахуйн комиссын гишүүд, аюулгүй ажиллагаа хариуцсан ажилтанд ч мөн сургалт их чухал. Гарч болох эрсдэл болон авч хэрэгжүүлэх арга боломжийн тухай мэдээллийг бүх түвшинд шуурхай хүргэхэд мэдээллийн үйл ажиллагааны гол зорилго оршино.

Түүнчлэн байцаагч нарын болон аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх сургалт нь ХААЭА-г дэмжихэд онцгой үүрэгтэй. Зааварлагч нар нь засгийн газар, үйлдвэрүүд болон бусад байгууллагаас сонгогдсон байдаг. Сургалт нь зөвхөн боломжит аюулаас сэргийлэх болон орон нутгийн зөв шийдвэр гаргахад бус, эзэд, ажилчдын оролцоотойгоор үйлдвэрийн түвшинд үйл ажиллагааг яаж зохион байгуулах вэ гэдэгт хэрэгтэй байдаг. Аюултай машин, техник, тоног төхөөрөмжийн нийлүүлэлт, хийц, чухал шаардлагатай химийн бодисын тухай сургалт ч байж болно.

Олон оронд ХААЭА-н сургалтыг олон нийтийн байгууллага болон эзэд, ажилчдын дунд тусгай даалгаврыг хэрхэн хийж гүйцэтгэх хүрээнд зохион байгуулж болно. Энэ нь үр дүнтэй туршлагыг харилцан солилцох, онц аюултай ажлын чиглэлээр сургалтыг явуулах аргыг хэрэглэх, сайжруулахад онцгой ач холбогдолтой.

Өнөөгийн нөхцөлд сургалтын үйл ажиллагаа нь өндөр түвшинд хүрч, ХААЭА-н хэрэгцээ, шаардлагад нийцэн явагдаж байна. Сургалтын үйл ажиллагаа нь:

- Орон нутгийн шаардлагыг харгалзсан сургалтын бодлого боловсруулах
- Салбар бүрт сургалтын дэд бүтэц бий болгох
- Сургалтын хөтөлбөрийн үйл ажиллагааг хөдөлмөрлөх орчин, бодит үр дүнд чиглүүлэхээр зохион байгуулах
- Сургалтын хөтөлбөрийг орон нутгийн нөхцөл байдалд тохируулан тухайн орон нутгийн хэлээр заахаар тусгаж, хэрэглэхэд бэлэн сургалт, мэдээллийн материалаар хангах
- зааварлагч нарын сургалтын хөтөлбөрийг тухайн орон нутгийн тэргүүн туршлагаар баяжуулж, сургалт явуулж байх

■ *Удирдлагын сургалт*

Захирагч болон хянагч нарын хувьд тэдний хүлээх үүрэг хариуцлагыг хэрхэн гүйцэтгэх талаар дараахи зүйлүүдийг багтаасан удирдлагын сургалт онцгой ач холбогдолтой.

- Үйлдвэрийн ХААЭА-н бодлого бүх ажилчдад ойлгомжтой байх
- Ажилчдын ажиллаж буй хөдөлмөрийн аюултай нөхцөл бүхий ажлын байрны тухай, эрсдлээс учирч болзошгүй үр дагаварын талаар заавар мэдээлэл өгөх
- Дагаж мөрдөх ёстой бүх дүрэм журмын хэрэгжилтийг шалгах

- Эрүүл мэндэд нөлөөлөх болон аюултай нөхцөл, аюултай үйл ажиллагааг олж тогтоох
- Ажлын шаардлагад нийцсэн ажлын тусгай хувцас, нэг бүрийн хамгаалах хэрэгслийн ашиглалтыг шалгах
- Аюултай нөхцөл байдал, багаж хэрэгсэл буюу шаардлага хангахгүй ажлын тусгай хувцас, хамгаалалтын хэрэгслийн талаар ажилчдад мэдээлдэг болгох
- Аюултай нөхцөл байдал үүсч байгаа ажлын байранд байнгын хяналт хийх

Хянагч нар нь ажилчдын ажлын байрны ХААЭА-н хяналтыг тавьж байдаг тул тэдэнд үүрэг, хариуцлагаа хэрэгжүүлэх эрх мэдлийг нь өгөх ёстой. Захирагч, хянагч нар нь аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн үйл ажиллагааг хянахад бэлтгэгдсэн байвал зохино. Энэ нь аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн асуудалтай холбогдсон аливаа шийдвэрлэвэл зохих арга хэмжээг зөв тодорхойлоход тэдэнд их ач тустай.

Байгууллагатай гэрээгээр буюу түр гэрээгээр ажиллах ажилчдын аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн асуудлыг стандартын дагуу хангана. Гэрээгээр ба түр гэрээгээр ажиллагсад ч үйлдвэрийн ХААЭА-н дүрмийг биелүүлэх үүрэгтэй.

■ *Шинэ ажилчдын болон давтан сургалт*

Эзэд бүх түвшин дахь захирагч, хянагч, ажилчдыг аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн сургалтанд хамруулах үүргийг хүлээнэ. Ажилчид нь тэдний ажлын онцлогт тохирсон аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн заавар, мэдээллийг авах ёстой бөгөөд ажлаа өөрчлөх, өөр ажилд шилжих буюу шинэ тоног төхөөрөмж, технологийг нэвтрүүлэх тохиолдол бүрт дахин заавар авна.

Нэг удаагийн буюу өөр аюултай орчинд шилжин ажиллах үед ХААЭА-н заавар авах нь ажилчдын үүрэг байх ёстой. Энэ сургалтын гол агуулга нь аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн үндсэн ойлголтыг багтаасан байна. Шинэ ажилчдын сургалтын сүүлийн хэсгийг түүний хийж гүйцэтгэх ажлын байранд хийвэл зохино.

Сургалт нь дэлгэрэнгүй, ажлын бүх эрсдэлийг хамарсан, бодит аюулыг харуулсан, урьдчилан сэргийлэх арга хэмжээ, анхны тусламжийн асуудлыг тусгасан байх ёстой. Энэ нь зөвхөн ажиллах горимыг хамарсан бус эрсдэлийг зайлуулах мэдлэг, ур чадварыг дээшлүүлэхэд чиглэнэ. Сайн бэлтгэгдсэн ажилчид нь өөрсдийгөө үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчлөлөөс үүсч болох үр дагавраас хамгаалж чадна.

Сургалт явуулж байх үед шууд мэдээллээр цаг тухайд нь хангах шаардлагатай. Аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн мэдээллийн элба нь сургалт хир зэрэг үр өгөөжтэй байгааг хянаж болох юм.

Сургалтын зардал нь ажилчдаас гарах ёсгүй.

■ *Зааварлагч нарын сургалт*

Сургалтын үйл ажиллагааны амжилттай болох үндэс нь зааварлагч нарын

сургалт юм. Энэ сургалт нь урьдчилан сэргийлэх бодит нөхцөл байдалд чиглэсэн, түүнийг хамарсан байх ёстой бөгөөд зааварлагч нар нь өөрсдөө сургалтыг хэрхэн зохион байгуулах талаар заавал мэдвэл зохино. Тэд аюултай нөхцөл бүхий хөдөлмөрийн талаар онцгой мэдлэгтэй болж, түүнийгээ бусдад мэдээлэх ёстой.

Сургалтыг үр дүнтэй болгоход сургалтын сайн хөтөлбөр, сургалтанд ашиглах материал онцгой чухал юм. Хянах хуудас, сурах бичиг, гарын авлага, мэдээллийн хуудас, заавар зэрэгт онцгой эрсдэл тохиолдсон үеийн бүх л мэдээллийг багтаасан байх ёстой. Аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн судалгааны төвийн мэргэжилтэнгүүдтэй хамтран ажиллах нь чухал.

10. ИЖИЛ ҮЙЛДВЭРЛЭЛ- ӨРГӨН ХҮРЭЭТЭЙ АЖИЛЛАГАА

Аж үйлдвэрийн салбар дахь зарим үйлдвэрүүд нь хоорондоо төстэй үйлдвэрлэл явуулдаг учир аюултай нөхцөл, шийдвэрлэвэл зохих ХААЭА-н ижил асуудлуудтай байдаг. Зарим орны практикаас үзэхэд энэ асуудлыг шийдэхэд энэ үйлдвэрүүд хамтран ажиллах нь сайнаар нөлөөлдөг байна.

Аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн талаарх нийтлэг асуудлыг үйлдвэрлэлийн өргөн хүрээнд авч үзэхэд :

- Аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн талаар хамтарсан арга хэмжээ явуулах.
- Үйлдвэрлэлийн түвшинд уулзалт, семинар зэрэг үйл ажиллагааг хамтран зохион байгуулах
- Хөдөлмөрийн аюултай нөхцөл бүхий ажлын байрны хүрээн дэх үйл ажиллагааг сайжруулах, эрсдэлийг багасгах арга хэмжээг хамтарч хэрэгжүүлэх
- Хөдөлмөрийн аюултай нөхцөл бүхий ажлын байранд сургалтыг хамтран явуулах
- Арга туршлагаа солилцох, үүнд уулзалт, семинар, сургалт, бодит мэдээллийн материалыг ашиглах (хайрцаг 5 тодорхойлов)
- Удирдлага ба сургалтын хүрээнд аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн асуудлаар хамтран ажиллах.

Үйл ажиллагааг хэрхэн хэрэгжүүлэх талаар ижил төстэй үйлдвэрлэл явуулдаг газруудад эзэд, үйлдвэрчний эвлэл болон бусад байгууллагуудтай хамтарч зөвлөлгөөн явуулах нь үр өгөөжтэй байдаг юм.

Хайрцаг 5. *Үйлдвэрлэлийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн асуудлыг сайжруулах: Австралийн жишээ*

1992-95 онд Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн талаар явуулах Нэгдсэн Стратегийн төлөвлөлтийн дагуу, Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн Австралийн Үндэсний Комисс нь үйлдвэрлэл дэх нэн түрүүн хэрэгжүүлэх 3 ажлын нэг нь ХААЭА-н асуудал гэж тодорхойлсон юм. /ХААЭА стандартын болон ХААЭА-н талаар эрдэм шинжилгээний үйл ажиллагаа явуулах асуудлууд нь нөгөө хоёр асуудал нь юм/

Энэ төлөвлөгөөний гол зорилго нь үйлдвэрлэлийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйг сайжруулах, үйлдвэрлэл дэх үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчлөлийн тоо хэмжээ, үечлэл, хохирлын өртгийг бууруулахад оршино. 1992-93 онд Австралийн Үндэсний Комиссийн бизнес төлөвлөгөөнд дараах үндсэн зүйлийг тусгав:

- Үндэсний үйлдвэрлэлийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн бодлого болон төлөвлөгөөг тодорхой сонгож авсан салбарт зөвлөх мэргэжлийн хэсгийг томилон ажлуулж, хэрэгжүүлүүлэх
- Эзэд болон үйлдвэрчний эвлэлийн байгууллагуудтай холбоо тогтоох
- Үйлдвэрлэл дахь аюулгүй ажиллагаа эрүүл ахуйн асуудлаар хамгийн сайн туршлагыг судлах
- Семинарыг зохион байгуулах
- Туршлагуудыг хэрхэн хэрэгжүүлэх, ашиглах талаар тайлбарлаж, нийтийн хүртээл болгох
- Үйлдвэрлэлд хэрэгжиж буй аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн стандарт, гарын авлагыг сайжруулах,
- Компьютерийн мэдээлэл болон хэвлэн нийтлэлийн мэдээллийг сайжруулах, үйлдвэрлэлийг сургалтын багаж хэрэгслээр хангах
- Захирагч, хянагч, аюулгүй ажиллагааны асуудал хариуцсан хүмүүс болон аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн хорооны гишүүдийг сургалтанд хамруулах

■ *"ХАМГИЙН САЙН" туршлагаа солилцох*

Үйлдвэрлэлийн түвшинд туршлагаа харилцан солилцох нь онцгой ач холбогдолтой байдаг. Ижил төстэй нөхцөл бүхий үйлдвэрүүдийн дунд "хамгийн сайн туршлагатай" үйлдвэрийг тодорхойлж ажиллахад үр дүнгээ өгдөг. Тэдний үйл ажиллагаа болон ололт амжилтыг мэдээлэх нь зүйтэй. Сонирхож буй үйлдвэрлэлд бодит ашиг тустай шийдлийг тайлбарласан сургалт мэдээллийн материалыг тарааж өгөх нь зүйтэй. Тухайлбал: Аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн асуудлыг бага зардлаар сайжруулах жишээнүүд их чухал. Сургалтын материалууд нь зааварлагч, захирагч,_ хянагч болон аюулгүй ажиллагааны асуудал хариуцсан ажилтан, мөн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн хорооны гишүүдэд үйлдвэрлэл дэх онцгой аюултай нөхцөл бүхий хөдөлмөрийн харьцаанд нэмэр тус үзүүлж чадна.

ажилтан, мөн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн хорооны гишүүдэд үйлдвэрлэл дэх онцгой аюултай нөхцөл бүхий хөдөлмөрийн харьцаанд нэмэр тус үзүүлж чадна.

ЭНЭ ТАЛААР ОУХБ-ААС ГАРГАСАН НОМ, ХЭВЛЭЛ

1."Аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн нэвтэрхий толь" (Женев. 1983)
2. "Өндөр бүтээмж ба ажиллах сайн нөхцөл" (Женев. 1988)
3. "Хяналтын үндсэн арга":Сургалтын материал (Женев. 1990 2 дахь хэвлэл)

Энэхүү номын эх хэвлэлийг ОУХБ-ын Ази номхон далайн бүс нутгийн Бангкок дэх товчооноос эрхлэн "Preventive measures in hazardous occupations in Asia" нэртэйгээр ОУХБ-ын 75 жилийн ойгоор 1994 онд хэвлэсэн болно.
Зохиогчийн эрх (с) Олон улсын хөдөлмөрийн байгууллага1994 он.

ISBN 92-2-910709-3

Орчуулсан Д. Цэцэгбадам, Х. Золжаргал
Хянан тохиолдуулсан Л. Баасанхүү, Ц. Энхтайван

НҮБ-ын бодлого үйл ажиллагааны дагуу ОУХБ-ын хэвлэлийн ажилтнууд болон хэвлэлийн материалууд аливаа улс, орон, нутаг дэвсгэр ба түүний удирдлага, хил хязгаарын хууль зүйн статусын талаар ОУХБ-ын үзэл баримтлалыг илэрхийлэхгүй болно.

Судалгаа болон бусад материалд туссан ямарч үзэл баримтлалыг зөвхөн зохиогч хариуцах ба тэр үзэл баримтлалын талаар ОУХБ хариуцлага хүлээхгүй.

Пүүс болон худалдааны бүтээгдхүүний нэр, үйлдлийг дурдсан нь ОУХБ-д хамаарахгүй бөгөөд ямар нэг пүүсийн болон худалдааны бүтээгдхүүний нэрийг орхигдуулсан нь түүнийг хүлээн зөвшөөрөөгүй гэсэн үг биш юм.